



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

Аудитын дүнтэй холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай

2015 оны санхүүгийн тайлангийн аудит, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудит, орон нутгийн хөгжлийн сангийн нийцлийн аудитын дүнгийн тухай аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Цогбадрахын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Цогбадрахад ДААЛГАХ нь:

1.Аудитын дүнгээр хүргүүлсэн төлбөрийн акт албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг хангуулж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулах.

Хоёр. Аймгийн Засаг дарга Д.Батлутад ДААЛГАХ нь:


1.Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж, төсвийн орлого бүрдүүлэх, зардал хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, орон нутгийн төсвийг хэмнэлттэй үр дүнтэй зарцуулах, судалгаа тооцоолол хийх, төсвийн сахилга батыг хангуулах.

2.Нийт төсвийн байгууллагуудын анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэл хөтлөлтөд анхаарч, төсвийн шууд захирагч, нягтлан бодогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бараа материал, авлага, өр төлбөрийн үлдэгдлийн өсөлтөд судалгаа хийх, үлдэгдлийг бууруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төсвийг бодитой төлөвлөх.

3.Төсвийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллах.

4. Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг холбогдох хууль журамд нийцүүлэн хэрэгцээ шаардлагатай уялдуулж, бодитой төлөвлөх, хэлтэс албадын ажлын уялдааг сайжруулан хяналт тавих.

5. Хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн зам, талбай болон СӨХолбооны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тухай бүр эзэнжүүлж, өмчийн бүртгэлд авах.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА



The stamp is rectangular with a double-line border. Inside, there is a central emblem featuring a traditional Mongolian pattern. On either side of the emblem, there are vertical columns of text in Mongolian script. The text on the left side reads 'МОНГОЛЫН ХАМГААГАХ, ХАМГААГАХ, ХАМГААГАХ' (Mongolian Conservation, Protection, Conservation). The text on the right side reads 'МОНГОЛЫН ХАМГААГАХ, ХАМГААГАХ, ХАМГААГАХ' (Mongolian Conservation, Protection, Conservation). The text at the bottom of the stamp reads 'МОНГОЛЫН ХАМГААГАХ, ХАМГААГАХ, ХАМГААГАХ' (Mongolian Conservation, Protection, Conservation).